

КОНСТАНТИН СИМОНОВЫН ТУХАЙ ДУРСАХ НЬ

К 70 – летию победы в Великой Отечественной войне

“Вопросы литературы” Российская Федерация.

Москва. 2015. №3

Константин Долгов

Долгов. К.М. – Оросын Шинжлэх Ухааны Академийн Философийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, философийн шинжлэх ухааны доктор, профессор. Философи, улс төр, дипломат харилцаа, шаашин, урлаг, утга зохиол, соёлын салбарын хүрээнд судалгааны ажил эрхэлдэг. “Оросын урлаг болон баруун Европын гоозүйн үзэл баримтлалд гарсан өөрчлөлт” /2004/, “Кьеркегороос Камю хүртэл : философи, гоозүй, урлаг” /2011/ зэрэг номуудын зохиогч.

Дайны жилүүдэд өсвөр насны бүр жаахан хүүхэд байх үедээ би анх Константин Симоновын нэрийг тэр үед хүүхэд багачууд бидний мэдээжийн жинхэнэ хүслэнт сонирхолыг төрүүлэн дуудаж байсан түүний фронтын сурвалжлагуудтай холбоотойгоор анх сонсож байсан билээ. Хожим манай эх оронд түүний яруу найраг нэн ялангуяа “Хүлээ намайг” хэмээх гайхамшигт шүлэг нь дуурсах үед тэрээр аль хэдийн манай хамгийн нэр хүндтэй уран бүтээлч, яруу найрагчдын нэг болсон байсан бөгөөд улс орон даяараа түүнийг хайрлан дээдэлдэг байлаа.

Он жилүүд улиран өнгөрч би Москвад амьдран суух боллоо. Би “Коммунист” сэтгүүлд зөвлөхөөр ажиллахын зэрэгцээ дээд сургуульд багшилж, янз бүрийн уулзалт, цуглаан гэх мэт арга хэмжээнүүд дээр түүний хэлсэн үг нэг бүрийг шимтэн сонсож улмаар түүний хэвлүүлэн гаргасан өгүүллэг, тууж, тэмдэглэл, роман болгоныг уншиж, түүний зохиол бүтээлүүдээр хийсэн кино, жүжиг болгоныг үзэж, дараа нь бүр түүнтэй биечлэн танилцсан билээ.

Би, “Урлаг” /”Искусство”/ хэвлэлийн газрын захирлаар ажиллаж байхдаа К.Симоновын уран бүтээлийг нэн сайн мэддэг зохиолч, яруу найрагч, жүжгийн зохиолч гэх мэтээр урлаг соёлын зүтгэлтнүүд олон арван хүмүүстэй уулзаж учирч явлаа. Тэрчлэн ЗХУ-ын Коммунист Намын Төв Хорооны Соёлын хэлтэст уран зохиолын тасгийн эрхлэгчээр намайг ажиллаж байх үед анхлан түүнтэй хамтран ажиллаж, шууд харилцах завшаан надад тохиосон юм.

Олон он жилүүдийн турш тэрээр надруу

утасддаг байлаа. Зохиолчдын Хороон дээр болдог янз бүрийн уулзалт, зөвлөгөөн, бага хурал дээр ч байнга л тааралдаж уулзаж ярилцана, бүр Төв Хороон дээр ч нэг бус удаа биечлэн ирж надтай уулзаж хөөрөлдөн төвөгтэй, хүндрэлтэй олон асуудлуудын талаар бид хамтран хэлэлцдэг байв.

Бидний харилцааны хэрээр би түүнийг зөвхөн сэтгүүлч, яруу найрагч, зохиолч гэхээс нь илүүтэйгээр ерөөс түүнийг хүн гэдэг талаас нь илүү сайн мэдэх болсон бөгөөд хүнийхээ хувьд тэрээр үнэхээр сэтгэл татам хүн байж, миний зүрх сэтгэлийг үүрд эзэмдсэн билээ. Энэ бол залуухан, овор багатай, цэвэрхэн тэгш биетэй, цаг ямагт энгийн мөртлөө маш аятайхан зохимжтой хувцасладаг их гоё хүн байлаа. Тэрээр хэнд, хэзээ, юуг, яаж, ямар байдлаар хэлэх вэ гэдгээ үргэлж боддог, ямар нэг үйл явдал болон хүмүүст хэзээ ч яаран үнэлэлт дүгнэлт өгдөггүй их бодлоготой, хэрсүү хүн байсан. Энэ нь ямар нэгэн айдас хүйдэс, болгоомжлолоос ч болдог юм биш харин сайн боловсрол, сайн хүмүүжил олж авсан жинхэнэ сэхээтэн хүмүүст байдаг өөрөө өөртөө болон бусдад ханддаг гайхамшигтай төлөв төвшин харьцаа, ер бусын хүнлэг ноён нуруутай зан чанарынх нь хүч чадлаас шалтгаалдаг байсан юм. Би түүнээс ямар нэг юмны тухай болон хэн нэгний тухай туйлширсан, хатуу ширүүн таагүй үг яриа хэзээ ч сонсож байгаагүй. Тэр их энгийн ярина, бүр ямар нэг юм түүнийг зэвүүцүүлж, бухимдуулсан ч дуугаа өндөрсгөхгүй. Манай эдүгээ цаг үед ховорхон тааралдах болсон, дотоод ертөнцийнхөө хувьд жинхэн эрхэмсэг сурвалжит язгууртан шинжтэй түүний дүр төрх нэн ялангуяа хэл ярианд нь бүгд татагддаг байсан. Өөрийнхөө эрин цаг үед асар

их юм үзэж туулсан, ухаалаг, сэтгэл татам, утга төгөлдөр амьдарсан энэ хүнтэй ярилцаж суухад үнэхээрийн тааламжтай, сайхан байдаг байлаа.

Би түүний амьдралын түүхийг мэднээ, тэр ч бүү хэл түүний гэр бүлийн тухай ганц нэг юм ч сонсож л байсан гэвч энэ асуудлууд миний сонирхлыг огтхон ч хөнддөггүй, тэр өөрөө ч ярьж байгаагүй, би ч мэдээж асууж шалгааж байгаагүй. Түүний мэргэжлийн үйл ажиллагааны тухайд гэвэл тэрээр юуны өмнө Аугаа Их Эх Орны дайны бүх фронтууд дээр байсан цэргийн сурвалжлагч хүн, нөгөө талаар тухайн цагийнхаа үзэл суртал, албан үүргийнхээ дагуу Зохиолчдын Холбооны нарийн бичгийн дарга, “Шинэ ертөнц” /”Новый мир”/, “Утга зохиолын сонин” /”Литературная газета”/ сэтгүүлийн ерөнхий редактораар нилээдгүй олон жилээр ажиллаж, нийгэм олон нийтийн үйл ажиллагаанд тогтмол, идэвхтэй оролцож байсан энэ хүнд би ч асуудал тавьж, тэрээр өөрөө ч энэ тухай /гэр бүлийн амьдралынх нь тухай ярьж байх шиг байна – С.Э/ надтай ярилцаж байсан бүх зүйл бүрэн тодорхой билээ.

Тэрээр заримдаа над дээр ирэхдээ өөрийн шинэхэн хэвлүүлсэн номоо авч ирээд гарын үсгээ зурж, дурсгал болгон өгнө, тэр нь “Миний эрхэм хүндэт амьдай Константин Михайловичид...” гэж эхлэнэ. Энэ үедээ тэрээр “Таны зөвлөгөөг сонсох нь надад сонирхолтой байх болно, энэ тухай зохиолоо уншиж байх үедээ тантай ярилцаж байсандаа” гэж заавал хэлнэ. Би мэдээж түүний тууж, романуудыг машинд анхааралтай, халуун сэтгэлээр уншина, түүний шинэ бүтээлүүдийн агуулгын талаар удтал хэлэлцэнэ. Энэ ярилцлагын үеэр тэрээр өөрийн шинэ шинэ өгүүллэг, туужуудынхаа баримт, дүр дүрслэлүүдийн талаар тайлбарлан, санаа оноо дэвшүүлэх нь үнэхээрийн сонирхолтой бөгөөд гайхамшигтай байдагсан. Харамсаад харамсаад баршгүй нь би тэр үед бичлэг хийдэггүй байсан буюу яриаг нь бичиж авч байсангүй, олон олон нарийн нандин зүйлс ой тойнд маань тэр бүр хадгалагдан үлдэж чадсангүй.

Төрөлх эх орныхоо хамгийн өндөр дээд шагналуудаар удаа дараа шагнуулж, алдар хүндийн оргил дээр олон жил зогссон хүн, мэдээж, өөртөө хариуцлагатай, шаардлага өндөртэй хандаж сурсан хэдий ч хүрсэн өндөрлөгөөсөө доошлох үед төрөх сэтгэл санааны хямралаа огтхон ч илэрхийлэхгүй байхад хэцүү л байсан болов уу. Сүүлийн жилүүдэд тэрээр жаахан уруу царайтай харагдах болсон бөгөөд магадгүй бас

жаахан эмзэг ч болсон байх, учир нь зохиолчдын бүлгэм болон олон нийтийн бас улс төрийн тодорхой хүрээнийхний зүгээс өөрт нь шударга бусаар хандсаныг хүндээр мэдэрсэн байх.

Либераль шинэчлэгчид түүнийг Сталины талыг баримтлагч гэж тооцсоор байсан бөгөөд тэдний бодлоор өнөөг хүртэл /1960-аад оны Н.С.Хрушевын шинэчлэлийн үеийг хэлж байх шиг байна – С.Э/ ялангуяа дайны үед И.В.Сталиныг хурц тодоор шүтэн бишрэгч гэж үзэж байсан. Уламжлалдаа үнэнч, нилээд хуучинсаг консерватив байр суурьтай сэхээтэн хүн ч гэсэн тэрээр хэтэрхий чөлөөтэй байдлаар байнга үг хэлж, хараахан үнэлэгдээгүй, олны анхаарлын төвд орж амжаагүй авьяастнуудын хүч хөдөлмөрийг хамгаалж, тэдэнд янз бүрийн байдлаар тусламж дэмжлэг үзүүлэхээс буцдаггүй байсан.

Өөрийнх нь уран бүтээлийг ойлгож, дэмжих дэмжлэг байхгүй болж, ямар нэг байдлаар бүхий л улс орноосоо тусгаарлагдан, яг л нэгэнт яваад дууссан мэт нийгэм – олон нийтийн үйл ажиллагаа нь ч дэмжлэг авахаа болино, ер нь л ганцаардлыг мэдрэх болсон билээ. Бидний нэг бус удаагийн ярилцлаганд, тэрээр манай цэрэг эрсийн дунд амьдралаа золиослон байж явж цуглуулсан баримтууд болох цэргийн сэтгүүлчдийн ажлыг нь дутуу үнэлсэнд нилээд сэтгэл дундуур, урам хугарсан байдал байхыг би олж харсан. Энэ бүх цаг үед фронт дээр тулалдаж явсан ахмад дайчдын дундаас төрөн гарсан зохиолчид дайны тухай бичиж эхлээд, дайн дууссанаас бүр хойно фронтын сурвалжлагуудад нилээд ихэрхүү тоомсоргүй хандах хандлага цухалзаж эхэлсэн бөгөөд өөрсдийн биечлэн тулалдаж явсан байлдааны туршлага дээр үндэслэн бичсэн роман, туужуудаа К.Симонов мэтийн фронтын сурвалжлагч байсан уран бүтээлчдийн зохиолуудаас дээгүүр тавих болсон юм.

К.Симоновын хамгийн гол зовнилын нэг нь Аугаа Их Эх Орны дайнд оролцогч, бодит гэрчүүдийг илэрхийлж чадах захидал – дурсамжууд болон цус урсгасан аймшигт дайны үнэн зөв баримтуудаар архив, төв байгуулах явдал байсан нь жир нэг тохиолдлын, санамсаргүй хэрэг ч биш байсан байхаа. Тэр үе үе Подольск явж энэ ажлаа бүтээхийн тулд маш их цаг зав, хүч чадлаа зориулсан билээ. Тэрээр дайны тухай баримтат төрөл зүйлээс гадна дайны сэдэвт уран сайхны зохиол бүтээлүүдийн

үнэ цэнэ, ач холбогдлыг сайтар ойлгож байсан юм. Манай ард түмний амьдралд тохиолдсон түүхийн энэхүү аугаа их үйл явдлын нэгдмэл дүр зургийг бүтээхийн тулд, ямар их гарз хохирол амсаж байж, Аугаа их ялалт ямар их үнэ цэнээр ирсэнийг нүдээрээ үзэж, амьдралаараа ухамсарласан хүний хувьд, энэхүү ялалт манай орны хувьд төдийгүй бүх дэлхий дахины хувьд ямар аугаа их ач холбогдолтой болохыг тэрчлэн дайны явц, түүний үр дүнг өөрөөр харах, дайны жилүүдийн үйл явдлыг гуйвуулах оролдлого бүр дайны төгсгөл үеэс л зарим улс орнуудад эхэлсэн тухай энэ сэдвийг босгож ирж, эдгээр сэдвээр ярилцахаас тэрээр хэзээ ч залхдаггүй, ядардаггүй байсан билээ. Хүн төрөлхтний түүхэн дэх энэхүү аймшигт их эмгэнэлийн тухай бүх үнэнийг яг байсан чигээр нь юу ч нууж хаалгүйгээр чин үнэнээр нь үзүүлэх нь зайлшгүй чухал гэж К.Симонов хатуу итгэж байсан юм.

Энд би К.Симоновыг фронтын найз нөхөд болон сэтгүүлчид, зохиолчид, өөрийн шүтэн бишрэгчид зэрэг хүмүүстэй харьцсан асар их захидал харилцааны хуулбар бий болгосныг дурсмаар байна. Энэхүү хуулбарууд нь урьд өмнө хэвлэгдэж байгаагүй хэдэн арван мянгаар тоологдох асар их хэмжээтэй байсан бөгөөд тэдгээр олон арван мянган захидлын нэгийг нь ч орхигдуулалгүйгээр бүгдэд нь заавал биечлэн хариу бичиж байсан нь үнэхээрийн гайхамшигтай билээ. Энэ нь түүний үүрэг хариуцлагаа ухамсарласан аугаа их сэтгэл, ер бусын онцгой давтагдашгүй хүнлэг чанарыг нь төдийгүй басхүү түүний гайхамшигт өндөр соёлыг гэрчлэн харуулдаг юм.

Дайны бүр анхны өдрөөс эхлээд л холбогдсон түүний фронтын сурвалжлагчийн ажил үүрэг нь К.Симоновын амьдрал уран бүтээлийн насан туршийн гол үйл хэрэг хэвээр үлдсэн билээ. Тэрээр зүрх сэтгэлийнхээ дуудлагаар сайн дураараа буюу албан үүргийнхээ дагуу энэхүү сэдэв рүү дахин дахин эргэж, ухамсартайгаар, тогтмол ханддаг байсан. Зарим үед мэдээж бидний ярилцлагын үеэр дайны тухай түүний зохиол бүтээлүүдээс ямар нэгэн жишээ татах үе ч гарна, мань хүн бас энх цагийн амгалан тайван амьдрал ахуйн хамгийн энгийн ерийн үйл хэрэг, ажил төрлийг ч ярина. Тэр энэ бүхний тухай ярьж суухдаа нэг л тийм ер бусын учир битүүлэг, түгшүүртэй бас зөн совинлог гэмээр, баяр баясгалантай, жаргалтай байдлаар маш тод, яруу сайхан ярьдаг бөгөөд тэрээр энэ бүгдийн тухай ярихгүй байж нэг л

чадахгүй байгаа юм шиг надад санагддагсан. Аль хэдийн өнгөрөн одсон дайны үед үзэж туулсан тэр бүх зовлон зүдгүүр нь түүний дотор байнга л оршиж, дотоод сэтгэлийг нь зовоож байх шиг байдаг бөгөөд манай улс орны амьдралын өөр бусад олон асуудлуудыг уран сайхны дүрслэлээр чөлөөтэй бичиж туурвин, эрх чөлөөтэй бодож, сэтгэх эрх эдэлсэнээрээ тэрээр энэхүү хүнд хэцүү нөхцөл байдлаасаа арай гэж нэг гардаг юм шиг надад санагддаг байсан. Дайны сэдэв тэрчлэн хожуу үеийнх нь яруу найрагт ч байр суурьтай хэвээрээ л байсан.

.....
Война...Как эти вдовы, с нею,
Наверное, повенчан я.
И ни короче, ни длиннее –
Срок давности – вся жизнь моя.
/1971/

Бэлэвсэн эхнэрүүд шиг энэ дайнтай,
Би, сүй тавьж ёсолсон ч юм билүү,
магадгүй
Богино ч бай, урт ч бай хамаагүй тэр
он жилүүд
Бүх амьдрал минь билээ, миний
/1971/

Константин Симоновын уран бүтээлийн гол утга нь “үлдэгсэд ба үрэгдэгсэд” билээ. /К.Симоновын дайны сэдэвт хамгийн алдартай цуврал зохиолуудын нэг дэвтэр нь “Живые и мертвые” гэж роман бий – С.Э/ Өөрийн хосгүй гайхамшигт, суу билигт авьяасынхаа ачаар тэрээр ирээдүй цаг үеийнхэний ой ухаанд мөнх үлдэх тавилан хутаг олсон гэгээнтэн хүн билээ.

Түүний хувийн ажлын тухайд зохиолоо хэвлүүлэх гэдэг ганц л ажил байдаг байсан. Түүний 60 насны ойгоор Зохиолчдын Төв Ордонд нам, төрийн удирдагчид, Зохиолчдын Холбоо болон уран бүтээлчдын бусад нэгдэл холбоодын төлөөлөгчид, мөн олон нийтийн байгууллагын төлөөлөгчид тэрчлэн түүний фронтын анд нөхөд г,м нийгмийн бүхий л хүрээний төлөөлөл гүн хүндэтгэлтэйгээр цугларсан билээ. Мэдээж тэргүүлэгчдийн суудалд суусан дарга, албан тушаалтнуудын зэрэгцээ амьдрал уран бүтээлийн ойд зориулсан тиймэрхүү ёслолын арга хэмжээн дээр үг хэлэх зөвшөөрөл байнга л олддог алдар суутнууд гээд бүгд л баяр бахдалтайгаар үг хэлсэн. Энд бас мэдээж цэргийнхэн ч байсан бөгөөд нэгэн генерал үг хэлэх зөвшөөрөл олдсон завшааныг ёстой л нэг бүрэн дүүрэн шавайгаа ханатал ашиглаж, К.Симоновыг ёстой л үнэнхүү

аугаа эх оронч хүн, онцгой иргэн, үнэхээрийн эрэлхэг зоригт цэргийн сурвалжлагч, цэргийн зохиолч хүн болох тухай бүхий л талаас нь чин сэтгэлээсээ бахдалтай ярилаа. Би К.Симоновыг харж суулаа, гэтэл тэрээр улам бүр баргар царайлан, генерал ч энэ үед үгээ дуусгахад тэрээр хурдан босоод өөрт нь огтхон ч байдаггүй эрс өнгөөр “Та энд юун тухай ярина вэ? Эрхэм хүндэт цэргийн хэвлэлийн газар дайны тухай миний нэг ч номыг хэвлээгүй байхад та намайг цэргийн сурвалжлагч, цэргийн зохиолч гэж юунд магтана вэ?” Ингээд дуугаа хураалаа. Танхимд үхсэн мэт нам гүм болов. Эцэст нь цэргийнхэний хэн нэг нь “Ийм юм байж болохгүй” гэж эсэргүүцлээ. Симонов : Тиймээ ийм юм байж болохгүй, тэгэхдээ би худлаа хэлдэггүй, миний бүтээлүүдийг хэн хэвлэснийг би бусдаас арай илүү мэднэ. Цэргийнхэн учрыг ойлголоо, үнэхээр түүний дайны сэдэвт алдарт бүтээлүүдийн нэгийг ч Цэргийн хэвлэлийн газар хэвлээгүй байжээ.

К.Симонов янз бүрийн зохиолчдын өгүүлэл, тууж, романуудыг хэвлэлд шилжүүлэхэд эсвэл зуслан, байр, амралтын бичиг олоход нь туслаач гэсэн хүсэлтэйгээр над дээр нэг бус удаа ирдэг байсан бөгөөд харин бидний халуун дотно үерхэл нөхөрлөлийн энэ бүх хугацаанд тэрээр өөртөө ямар нэг юм нэг ч удаа хэзээ ч хүсэж байгаагүй билээ. Би боддог юм. Тэр энэ чанараараа олон уран бүтээлчид, Зохиолчидын Хорооны олон дарга удирдлагуудаас үнэхээрийн ялгаатай хүн байсан. Лили Брикийн баримтат дурсамж, ярилцлагууд Итали хэл дээр хэвлэгдэн гарах үед тэрээр Италийн хэвлэлд гэнэт ихээхэн анхаарал хандуулах болсон. Энэ удаагийн хэвлэл бидэнд ч бас шүүмжлэлтэй хандсан байв. К.Симонов над руу утасдаж уулзахыг хүссэн. Надтай мэндлээд тэрээр Итали хэл дээр хэвлэгдсэн багавтар номыг удаавтар хөдөлгөөнөөр над руу дөхүүлээд ингэж хэлсэн билээг. Лили Брикийн гаргасан дурсамж энэ байна. Одоо үүнийг тойруулан баахан шуугиж эхлэх бизээ. Та үүнийг эргүүлж тойруулж хараад, уншиж үзнэ биз, тэгээд юу хийвэл дээр вэ гэдгийг хамтдаа бодоцгоовол зүгээр байх.

Би номыг маш хурдан уншсан, тэгээд тэнд ямар нэг онцгой шинэ зүйл болон ямар нэгэн ээдрээ төвөгтэй, хүндрэл учруулахаар “халуухан” сэдэв огт байхгүй болохыг мэдлээ. Тэгээд бид дахин уулзах үедээ би ингэж хэллээ энэ ном Лили Брикийн ойр дотны найз нөхөд болон түүний үе тэнгийнхэнд сонирхолтой байж

болох юм харин нийгэмд үзүүлэх нөлөөллийн хувьд нэг их анхаарал татах юм байхгүй учраас энэхүү хэвлэлийн тухайд онцгойлон ач холбогдол өгч, ямар нэгэн шийдвэр, үнэлэлт дүгнэлт өгөх шаардлага огт байхгүй гэлээ. Хэрэв Брик болон түүний найз нөхөд энэхүү номыг орос хэл дээр хэвлэн гаргахыг хүсэж байгаа бол дураараа л болог, ингэлээ гээд ямар нэгэн дуулиан шуугиан гарахгүй биз, муугаар бодлоо гэхэд ихдээ л шүүмжийн ганц нэг тэмдэглэл энэ тэр гарна л биз. Симонов үүнийг зөвшөөрч, асуудал ингээд хаагдсан билээ.

Өөр нэг жишээ байна. К.Симонов нэг удаа Ф.Кафкагийн нилээд бүтээлүүдийг хэвлэх хүсэлтэйгээр над дээр ирэх үед харин хэцүүхэн асуудал үүслээ. Энэ бол энгийн хялбар асуудал биш, учир нь Прагийн хаврын /1968 оны Прагт гарсан социализмыг эсэргүүцсэн бослогыг хэлж байна – С.Э/ нэг гол учир шалтгаан нь Ф.Кафкагийн өгүүллэгүүдийн үндсэн агуулга болох, нэг хүнийг тахин шүтэх ёс, захиргаадалтын дэглэм, дарангуйлал зэрэг сэдэв гэж үзэж байсан юм. Тийм учраас хэвлэлийн газар түүний /Ф.Кафка – С.Э/ бүтээлүүдийг орчин үеийн бус /эсэргүү – С.Э/ гэж үзэж байсан юм. Гэтэл Симонов болохоор харин энэхүү бүтээлүүдэд хортой бөгөөд бидэнд муу юм болохоор ямар ч аюултай юм байхгүй гэдгийг харуулахыг оролдсон.

Би Ф.Кафкагийн бүтээлүүдийг сайн мэддэг, тэдгээрийг орос болон немц хэл дээр нэг биш удаа уншиж байсан болохоор түүний бодол эргэцүүллийг би зөвшөөрч байлаа. Гэвч нэмэрт нь хэлэхэд тэр цаг үеийн манай үзэл суртлын дайснууд Ф.Кафкаг социализмын эсрэг ямар ч үндэслэлгүйгээр эргүүлж хэдийгээр социализмын үед зарим нэгэн сөрөг үзэгдлүүд илрэх төдий байдаг боловч Ф.Кафка бол социализмыг биш харин юуны өмнө хөрөнгөтний буюу капиталист нийгмийн байгууламжийг дүрслэн харуулсан гэж үзэж байлаа. Зүгээр л бүр 1924 онд нас барсан тэр хүнд социализм гэж юу юм бэ гэдгийг ойлгох, судлах боломж тэртэй тэргүй байхгүй байсан гэдэг нь хэнд ч ойлгомжтой шүү дээ. Бид хоёр Кафкагийн бүтээлүүдийг хэвлэж болно гэдэгт санал нийлж байлаа тэгээд ч түүний нилээд хэдэн зохиол тухайлбал “Үйл явц” /”Процесс”/, “Эцэгтээ бичсэн захидлууд” /”Письмо к отцу”/, тэрчлэн салангид туурь, сургаал номлолууд нь болон өдрийн тэмдэглэлүүд нь бүр тэр үед 1964-өөс 1968 оны хооронд орос хэл дээр хэвлэгдэн гарсан билээ. Гэвч харамсалтай нь Прагийн

хавартай холбоотойгоор Ф.Кафкагийн тэдгээр бүтээлүүд нилээдгүй олон жил хаагдсан билээ.

К.Симонов нэг бус удаа энэхүү асуудлыг сөхөж байсан боловч тухайн цаг үед Ф.Кафкагийн бүтээлүүдийг хэвлэх ажлыг бүтээж чадаагүй юм. Ф.Кафкагийн “Цайз”, “Америк” зэрэг гол гол бүтээлүүдийг хэвлэх ажил бүр 1980-аад оны төгсгөлөөр сая нэг хэрэгжиж хоёр, гурав, дөрвөн боть түүвэр зохиол нь уншигчдын гар дээр очсон билээ.

Бид К.Симоновтой манай олон үндэстний уран зохиол, урлаг соёлын тухай болон манай улс орны амьдралд тохиолдсон үйл явдлуудын талаар тогтмол хэлэлцдэг байлаа. Энэ тухайд түүний бодол, санал, эргэцүүллийг би үнэхээрийн гүн хүндэтгэлтэйгээр сонсдог байсан. Тэрээр уран сайхны болон амьдралын асар их дадлага туршлагатай хүн учир, түүний бодол сэтгэлгээ, үнэлэлт дүгнэлт нь үнэхээрийн гүн гүнзгий, сонирхолтой, итгэл үнэмшил төрүүлэхүйц байдагсан. Түүнтэй хөөрөлдсөн ярилцлага бүр шинэ шинэ мэдлэг, туршлагаар намайг баяжуулдаг байсан хэдий ч басхүү түүний биеийн чалх тэнхээ, ядарч доройтож буй байдлын улмаас ч юм уу ямар нэгэн сэтгэлийн зовнил, таагүй, сэтгэл дундуурхан байдаг болсон зэрэг нь миний анхаарлын гадуур үлдэж чадаагүй билээ.

Нэг удаа би биеэ барьж чадалгүй түүнээс “Константин Михайлович та зүгээр үү? Бие чинь өвдөөгүй биз дээ?” гэж асуусан. Тэр жаахан бодлогшироод намуухан дуугаар “Би хүнд өвдсөн, миний хувьд бүх зүйл ихээхэн тааруу байна, оройн цагаар нэн ялангуяа шөнө заримдаа дотор давчуурч, амьсгал бүтэх болсон” гэж яриу. “Үгүй, та тэгээд эм ууж байгаа биз дээ? Танд эмч нар тусалж байгаа биз дээ?” гэж би асуув. “Тэр үед нь би 30 – 50 грамм коньяк уудаг юм, тэгээд арай жаахан хөнгөрдөг” гэж тэрээр хариулав. Тэгэхэд нь би түүнд хамгийн сайн эмнэлэгт хэвтэж үзүүл, хамгийн сайн эмч нарт үзүүлж эмчлүүлэхийг санал болгов. Харин тэрээр ингэж хариулсан: “Одоо бүх юм аль хэдийн хожимдсон. Одоо надад хэн ч юугаар ч тус болж чадахгүй. Энэ хорвоо дээр амьд явах цаг хугацаа надад тун бага үлдсэн гэдгийг би мэдэрч байна.” Ийм гэнэтийн эрс шийдвэр сонсоод би яг л буудуулсан юм шиг болж, үнэхээр цочирдолд орсон бөгөөд юу хэлэхээ ч мэдэхгүй хэсэг сууж байгаад дараа нь ЗХУ-ын КН-ын ТХ-ны удирдлага зайлшгүй тохиолдолд хэрэгтэй бүх тусламжийг үзүүлнэ гэдэгт эргэлзэх хэрэггүй гэж хэллээ.

Энэ бүхний дараа бид бас дахин нэг удаа уулзаж, утга зохиол болон амьдрал ахуйн аар саар зүйлийн талаар ярилцаж суугаад салах үедээ би түүнд “Константин Михайлович та бол харьцангуй залуу хүн, танд хүч чадал, эрч хүч хангалттай бий, уран бүтээлийн эрч хүч, авьяас билгийн тухайд бол бүр ч ярих юм байхгүй, ойлгомжтой, тийм учраас та эрүүл мэндээ бэхжүүлж, илүү их зүйл бичиж, бүтээн туурвиж чадна шүү” гэж захилаа. Хариуд нь би түүнээс бүр ч илүү их сэтгэл өвтгөсөн, хүнд үгсийг сонссон билээ: “Константин Михайлович хэрвээ та намайг юу тэгтлээ их зовоож байгааг мэдмээр байгаа бол: бидний гадаад талд болон дотоод талд ерөөс бид бүхэнд бүгдэд нь сэтгэл зүрх зовоон тарчилгах юм маш их байна. Намайг хамгийн их шаналгаж, зовоож байгаа юм бол: би утга зохиолд маш их юм хийсэн, их ч юм бичиж туурвисан, тэр бүхнийг үнэн сэтгэлээсээ, зүрх сэтгэлийнхээ дуудлагаар бичиж байсан гэвч би хамгийн гол зүйлийг бичээгүй, харамсаад харамсаад баршгүй нь одоо бичиж чадах ч үгүй” Бид хоёр бие биенээ удаан харсан боловч хэн нь ч дуугарч чадсангүй, эцэст нь дэмий л бие биенийхээ гарыг барьж өрөвдөж харамссан сэтгэлээ илэрхийлээд салсан билээ. Хачирхалтай нь Ю.Трифонов, Л.Леонов нар мөн л өөрсдийн насан эцэслэхийн өмнөхөн надтай ярилцаж байхдаа мөн л “би хамгийн гол зүйлээ бичээгүй” гэж ярьж байсныг би хожим санадаг юм.

Удалгүй түүнийг Мичурины өргөн чөлөөнд байдаг клиникийн Төв эмнэлэгт хэвтүүлсэн бөгөөд тэрээр тэндээс дахин босож гарч чадаагүй билээ. Хожим нь түүнийг эмчилж байсан эмч нарын нэг нь К.Симоновын үхлийн гол шалтгаан нь түүний бие организм маш их дор орсон байсан гэж бидэнд хэлсэн юм.

К.Симоновыг насан эцэслэсний дараахан гэнэтхэн түүний эхнэр бидэнд утасдаж, уулзахыг хүслээ. Энэ уулзалт дээр түүний гэр бүлийн хүн К.Симоновыг гэрээслэл үлдээсэн гэдгийг шуудхан, ил тод, нээлттэй хэллээ. Энэхүү гэрээслэлдээ К.Симонов өөрийг нь Могилевын дэргэдэх Буйническийн талбарт оршуулахыг хүссэн байсан бөгөөд чухам энд тэрээр анх 1941 оны 6-р сард манай дайчид немцийн 39 танкийг устгаж, цус урсгасан, ширүүн тулалдаан хийсэн байлдааны ажиллагааны гэрч болсон бөгөөд дараа нь тэд бүслэлтийг сэтлэн гарч чадсан билээ. Чухам тэр л цагаас хойш энэ газар нутаг түүний хувьд хэзээ ч мартагдашгүй, хамгийн хайртай бөгөөд гүн хүндэтгэлтэй төрөлх дотно

газар нь болж хувирсан юм.

Би эхнэрт нь гэрээслэлийг нээлттэй, үнэнчээр дамжуулсанд талархаад, хэдийгээр ЗХУ-ын Коммунист намын Төв Хорооны удирдлага К.Симоновыг хүндэтгэлтэйгээр оршуулах тухай шийдвэрийг баталсан боловч нөхрийнхөө гэрээслэлийг биелүүлнэ гэдэг бол түүний хувьд өөрийнх нь ариун үүрэг, нэр төрийн хэрэг байх ёстой, ийм учраас энэ бол өөрийнх нь цэвэр хувийн хэрэг, харин энэ тухай бид хэнд ч юу ч хэлэхгүй, зөвхөн удирдлагад зориулсан эмгэнэлийн бичгийг хариуцаж бэлтгэн гаргана гэдгийг хэллээ. Чухам ингэж шийдсэн нь биднээс шалтгаалахгүй зүйл байлаа. Ингээд салцгаасан билээ.

К.Симоновын гэгээн дурсгалыг хүндэтгэж, хойдын буяныг үйлдэх цуглааныг Доны хийдийн оршуулгын газар хийсэн бөгөөд энгийн олон түмэн нэг их байсангүй, зөвхөн төрөл төрөгсөд, ойр дотныхон, ЗХУ-ын Коммунист намын Төв Хорооны төлөөлөгчид, Зөвлөлтийн Зохиолчдын Холбоо болон уран бүтээлийн бусад нэгдэл холбоодын төлөөлөгчид, фронтын анд нөхөд нь байлцлаа. Тэнд байсан бүх л хүмүүсийн нэгэн адилаар гайхамшигтай суу билигт авьяаслаг уран бүтээлч, сэтгүүлч, олон нийтийн зүтгэлтэн, давтагдашгүй онцгой, ер бусын аугаа их энэ хүний цаг бусын үхэлд үнэхээрийн, чин сэтгэлээсээ зүрх сэтгэл хөндүүрлэж байсан билээ. Гагцхүү түүний яруу алдарт нэр, суу билигт уран бүтээл нь л манай ард түмний зүрх сэтгэл, манай улс орны түүхийн хуудсанд үүрд мөнх хадгалагдан үлдсэнд л ялимгүй тайвшрах юмдаа.

К.Симоновын гэрээслэлийг биелүүлж, түүний чандрыг Буйническийн талбарт цацсан билээ. Энэхүү талбарын нэг захад буй том чулууны нэг талд К.Симоновын гарын үсэг амьдралын он жилүүдийн тэмдэглэлийг бичиж нөгөө тал дээр нь “Энэ талбарт 1941 онд болсон тулалдааныг тэрээр бүх амьдралынхаа турш санан дурсаж явсан бөгөөд энд өөрийн чандрыг цацахыг гэрээсэлсэн билээ” гэсэн бичээс бүхий дурсгалын самбарыг байрлуулсан юм.

К.Симоновын эхнэр Лариса Жадова ч басхүү нөхөртэйгээ үүрд мөнх хамт байхын тулд энэ талбарт өөрийнх нь чандрыг цацахыг гэрээсэлсэн бөгөөд түүний хүсэлтийг ёсоор болгосон. Энд сэтгэл тайван байх үнэхээрийн боломжгүй, зүрх сэтгэлийг догдлуулан

гуниглуулдаг газар билээ. Жинхэнэ гайхамшигт, яруу сайхан амьдрал тийнхүү эрхэмсэг яруу төгс амирлалыг олсон бүлгээ.

Энэ онд бид Аугаа Их Ялалтын 70 жилийн ойг тэмдэглэж байна. Энэ ой газар дэлхий дээр хэн бидэнд амьдрал бэлэглэж, хэн бидэнд ялалт авчирж өгсөн ач, гавьяа хоёрыг дурсан сануулах бизээ гэж найдаж байна.

Долгов. К.М. – Оросын Шинжлэх Ухааны Академийн философийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, философийн шинжлэх ухааны доктор, профессор. Философи, улс төр, дипломат харилцаа, шаашин, урлаг, утга зохиол, соёлын салбарын хүрээнд судалгааны ажил эрхэлдэг. “Оросын урлаг болон баруун Европын гоозүйн үзэл баримтлалд гарсан өөрчлөлт” /2004/, “Кьеркегороос Камю хүртэл: философи, гоозүй, урлаг” /2011/ зэрэг номуудын зохиогч.

Орчуулсан: С.Энхбаяр, доктор, профессор
(НХУС-ийн Уран зохиол, сэтгүүлзүйн тэнхимийн эрхлэгч)

05.09.2016